

Н.Нямдоржийн яруу найраг хийгээд түүний орон зай

Баатаржавын МӨНХБАЯР*

Монгол улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн,
Утга зохиол судлалын салбарын ЭШТА, доктор

Агуулгын товч: XX зууны уран зохиолыг судалсан олон судлаач 1960-1990-оны үеийг Монголын орчин үеийн уран зохиолын хөгжлийн чухал шат хэмээн үнэлсээр иржээ. Энэ үед дэлхийн хөгжингүй бичгийн зохиолд байдаг төрөл зүйлийн бүхий л тогтолцоо жигдрэн хөгжиж, урлах эрдэм, утга агуулгын гүнзгийрлээрээ дэлхийн утга зохиолын жишигт очсон юм. Хэдийгээр зохиолчид маань нэгэн үзэл суртлын дарамтад уран бүтээлээ туурвиж байсан ч, хүн төрөлхтний соёлын дэвшилтэт өв, өрнө, дорнын уран сайхны соёлын шим тэжээлийг зохистой хослуулан, шинийг эрэлхийлсэн нь утга зохиолын амьдралд 1930-аад оных шиг сэргэлт болж, өнөөдөр бидний шилдэгт тооцдог олон бүтээл гарсан юм. Эл шинэчлэлийн нэгэн эх сурвалж нь яруу найрагч Н.Нямдоржийн уран бүтээл болсон юм.

Н.Нямдоржийн уран бүтээл 1950-иад оноос эхэлжээ. Тэр цагийн олон залуусын авьяасыг таньж, үгийн урлагийн шилдэг төлөөлөгч болгосон Д.Сэнгээгийн нэгэн шавь нь Нямдорж мөн.

Түлхүүр үг: Н.Нямдорж, орчин үеийн яруу найраг, бичгийн зохиолын шинэчлэл

“... Намайг Хэнтий аймгийн 10 жилийг дүүргэх жилдээ сурч байхад “Зохиолч Д.Сэнгээтэй Аймгийн соёлын ордонд уулзалт хийнэ” гэсэнд очлоо. Ордон дүүрэн хүн. Суух сандал алга. Тайзны ойролцоо ойртон, хана түшин зогслоо. Шүлгээ уншиж буй нь нэрт жүжигчин тайзнаа жүжиглэх мэт. Нэг шүлгээ уншаад дуусмагц алга нижигнэж байлаа. Эцэст,

“Бичсэн шүлэгтэй хүн байвал унш” гэлээ. Сэтгэл хөөрсөн буриад хөвгүүн тайзнаа гараад аль болохоор өөр шиг нь шүлгээ унших гэж чармайлаа. Уншсан шүлгийн минь

“Алив!” гэж аваад их шохоорхон уншиж байснаа, өөрөө босон уншлаа. Уран унших гэдэг өөр юм билээ. Уншсан шүлгээ авч номынхоо

* © Б.Мөнхбаяр 2024

Email: munkhbayar_@mas.ac.mn

сав уруу хийгээд,

“Бусад шүлгээ аваад буудалд миний өрөөнд ир!” гэлээ. Би зүүдэлж байна уу даа гэмээр бодогдож билээ. Тийм том зохиолч ийм сайхан үг хэлэх шиг баяр яаж байх билээ?

“- Өөр шүлэгтэй хүн байна уу?” гэхэд хэн ч гарсангүй. Би бичсэн шүлгүүдээ аваад очлоо. Өөрөө авч уншингаа зарим дээр нь тэмдэг тавьж байлаа.

“- Хэддүгээр анги вэ?

- Төгсөх анги

- Ямар мэргэжил сонирхдог вэ?

- ЗОХИОЛЧ

- Овоо бужигнуулчихна биз? Би толгойгоо илэн,

- Үгүй дээ

- Захирлынхаа утсыг мэдэх үү? Хэллээ. Захирал уруу залган, миний төрх, сурлага, гэр орон бүгдийг асуугаад

-Танд нэг хүсэлт тавья. Энэ хүүгийн шүлгүүдийг уншихад яруу найрагч болох өнгө байна. Та эцэг эх өөртэй нь ярилцаад, та бүхэн зөвшөөрвөл энэ хүүг эртхэн МОСКВАГИЙН М.ГОРЬКИЙН УТГА ЗОХИОЛЫГ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦУУЛЪЯ. Би чихэндээ итгэж ядаж байлаа. Тэр сургуульд сурах сонирхол байна уу? Сурна гэх гэтэл хоолойноос дуу гардаггүй толгой дохилоо. Тэр сургуульд хэвлэгдсэн номгүй хүн ордоггүй болохоор Аймгийн утга зохиолын дугуйлангийнхныг цуглуулан, өөрийнхөө тэмдэглэсэн шүлгүүдийг уншуулан батлуулаад, аймгийн хэвлэлд өгч хэвлүүлсэн юм. Миний ээж, аав шиг л миний төлөө дөнгөж нүүр үзээд ингэж хөөцөлдөнө гэдэг ховор тохиолдол доо! Тэр сургуулийн хананд багшийн минь зураг байсан ба багш нар нь тун андахгүй их нэр хүндтэй оюутан нь юм билээ.¹”

хэмээн Нямдорж дурсжээ. Чухам энэ цагаас эхлэн түүний туурвил зүйн сэтгэлгээ, уран бүтээл, шүлэг яруу найргийн хараас, уур амьсгал, орон зай нь тэлж эхэлсэн байна. Ялангуяа Нямдоржийн танин мэдэхүй, уран сайхны сэтгэлгээ нь шинэ цагийн эхэн үе буюу 19-р зууны сүүлч, 20-р зууны эхэн үеийн бичгийн зохиолчдын туурвил зүйн арга барилтай гүн холбоо, нарийн шүтэлцээтэй байсан нь,

- нэг талаар монгол бичгийн зохиолын үндэсний уламжлалаа ачаалж тээсэн,
- нөгөө талаар өөрийн гэсэн сэтгэлгээний хэв маяг, туурвил зүйн арга барилтай гэдгээ харуулсан,
- гуравт, хэдий нийгмийн үзэл санааны хязгаарлагдмал орчин ноёлж байсан цаг үед ч гэлээ уран бүтээлч хүн сэтгэлгээгээрээ эрх чөлөөтэй байна гэдэг нь ямар үнэ цэнтэй зүйл болохыг ухааруулсан туурвил зүйн үзэгдэл

¹ Эрхлэн редакторласан Б.Мөнхбаяр “Төрийн хошой шагналт зохиолч Дашзэвэгийн Сэнгээ: Дурсгалын түүвэр”, Уб., 2016

болж, энэ бүхэн нь аяндаа “Нямдоржийн” гэх имиж болж төлөвшжээ. Эл төлөвшилийг тодорхойлохын эхлээд түүний уран бүтээлийн уламжлалын асуудлыг тодруулъя.

“Зохиолч” хэмээх мэргэжлийн хөдөлмөр буй болж, аман зохиол бичгийн зохиол хоёрын дунд харьцангуй зааг гарч эхэлсэн 19-р зууны уран зохиолд, ялангуяа Инжаннаши, Гуларанс нарын шүлэг зохиолд:

“Турван ямхын хулсыг барьж эндүү ташаа бичих минь
Гутал оймсыг бартал явж нэр ашгийг хөөхөөс дээр
Гунилтай болой, таны олон энэхүү амтыг эс мэдсэнээр
Гутруу үгийг дэмий л хэлж миний зоригийг харин буруулмуй”
гэх буюу эсвэл,
“Мянган оны учир шалтгааныг бийр бэхсээс асууж
Мяралзан эрээлжих үйл явдлыг судар бичиг лүгээ хэлэлцмүй
Миний энэ бие сэтгэлийн гүн чилсэн шалтгааныг
Мяташ үгүй хожмын мэргэд айлднам болов уу, үгүй юу?”

“Хүсэлтэй сонин утга уянга гэгч
Хөх үүл, салхинаа хөрвөх мэт
Хүмүүний сэтгэлийг хөдөлгөн эс чадваас
Хөнгөн бийрийг хөшиж юу хиймүй”

гэх мэтээр, найрагч зохиолчид уран бүтээл туурвихын учир шалтгаан, зорилго, хүсэл тэмүүлэл, улмаар уран бүтээлчийн хөдөлмөрийн үнэ цэнээ тунхагласан, өөрийнхөө хэн болохыг, ямар зохиолч болохоо тунхагласан шүлэг [бичгийн зохиол] олныг туурвисан байдаг. Тэгвэл Н.Нямдоржийн уран бүтээл яг л ийм замналаар, монголын сонгодог бичгийн зохиолчдын гаргасан мөрөөр явж ирсэн нь 1960-аад оны үес содон бичлэг байв.

“Өндөгний минь хээ
Өөрчлөгдөшгүй,
Хурууны минь хээ
Хувиршгүй,
Алганы минь хээ
Арилшгүй,
Миний хээ
Минийх...”

“Энх төрийн минь далбаан дээр
Эрдэнийн хоёр загас
Эрхлэнхэн наадна
Энэ хоёр загасны нүдээр
Эх орноо би харж байна”

“Эрлээр дүүрэн миний цээж
Эзгүй хаягдсан байшин ч биш
Элэгдэн цоорсон сав ч биш

Хайраар дүүрэн миний цээж
Хан Хэнтийн харагдах сүр
Хатан Ононы хаялах долгио

Мөрөөдлөөр дүүрэн миний цээж
Мөхөж сөнөсөн галт уул ч биш
Мөстөн хөлдсөн хонгил ч биш

Бухимдлаар дүүрэн миний цээж
Бургилан буй халуун рашаан
Буцлан буй галт уул”

зэрэг шүлгүүд нь, яг л Инжаннаши, Гуларанс нарын бичсэн шиг, шүлэг зохиол бичих туурвихын учир шалтгаанаа, зорилго, хүсэл тэмүүлээ илэрхийлсэн, ерөөс өөрийгөө хэн болохыг өөрөө тунхагласан үзэл баримтлал бүхий байгаа юм. Энэ бол “Би”-гээ “Би” нь товойлгосон эгоизм биш, гоо зүй, уран сайхан туурвил зүйн эрх чөлөөт байдлын мэдрэмжээ илэрхийлсэн хэрэг юм.

Ингэж түүний уран бүтээлийн сэтгэлгээ, туурвил зүйн имиж, хэв маяг нь монгол бичгийн зохиолын туурвил зүйн хэв маягт суурилсан хандлагатай болж ирсэн учраас хожим түүнээс ямар шүлэг зохиол гарах нь бараг л тодорхой байлаа. “Үүлэн бор”, “Дорно”, “Онон хатан ээжий”, “Цус”, “Хүн чулуу”, “Амарбаясгалант”, “Од”, “Зөгий” тэргүүт олон шүлэг нэг талаас түүний нэрийн хуудас болохын зэрэгцээ нөгөө талаас энэ мэт шүлэг зохиол нь тэр цаг үеийнхээ нийгэм, гоо зүй, уран сайхны стандарт бус сэтгэлгээний классик маягийн жишээ болж байжээ. Н.Нямдорж “Дорно” шүлэгтээ:

“Энэ Дорно
Энэ өрнө биш, Дорно
Эрдэм соёлтой эртний их Дорно
... Сэтгэл ахуйгаар нөлөөлөгдөн тэдэнд автаагүй
Цэвэр үлдсэн өвөрмөц сайхан Дорно!
... Өөрөө бүтэн биеэ даасан Дорно.
Энэ эртний их Дорно
Энэ энэрэнгүй их Будда.
Энэ манхайн цайх үүр
Энэ мандан гарах нар
Энэ Дорно!”

гэж бичжээ. Энэ шүлгийг хүн төрөлхтөнд байгалиас заяасан, унасан газар, угаасан усаараа бахархдаг, дээдэлдэг үзэл санааны илрэл гэж, аль нэг нь

нөгөөгөөс илүү гэсэн үнэлэмж хэмээн үзсээр иржээ. Гэтэл Н.Нямдорж, дорноос туяардаг үүр-дэлхийн гэгээ нь болж, дорноос манддаг наран нь ертөнцийг гэрэлтүүлж, дорнын энэрэл хайр нь дэлхийн хүмүүний хайр болдгийн шалтгаан нь “Цэвэр үлдсэн өвөрмөц сайхан Дорно!” учраас тэр юм гэжээ. “Цэвэр үлдсэн” гэдэг энэ үг л оршихуйн гүн ухаан -Унаган төрх гэгч зүйлийн илэрхийлэл болж байна. Ийн үзвэл Нямдорж дорнын унаган төрхийг хэвээр хадгалах, хамгаалах нь ертөнцийн оршихуй, амар амгалангийн нэгэн загвар болох тухай, дорнын экологийн талаар 1960-аад онд дуугарч байсан байх нь. “Онон хатан ээжий” шүлгийнхээ эхлэл төгсгөлийг:

“Цалгих долгио таслаагүй
Өргөн Ононы урсгал
Цагийн уртад замхраагүй
Өнө холын дурдатгал ...

... Олон бидний гараар
Аугаа бүхэн босно
Онон хатан эжий минь
Алдарт үеийг тосно”

гэсэн бадгаар хашсан нь өнгөрсөн -одоо - ирээдүй гурван цагийн мөн чанарын дүрслэл болжээ. Өөрөөр хэлбэл үл буцах, үл зогсох, үл харагдах цаг хугацаа, орон зай, үйл явдлын бодит зураглал болсон ажээ. Тэгвэл:

“Мэдэх үү миний сайхан Монголыг
Мэдэхийг хүсэх үү өнө эртний Монголыг
Дэлхийн дэвсгэрт Монгол улс
Дэвсгэр нутгаараа хэний ч нүдэнд торно
Гай болж газрын зураг шагайдаггүй
Ганц нэг гаднынхан мэдэхгүй ч байж магадгүй
Тэгвэл тэнүүн Азийн элэг
Тэртээ европын хормойг
Жижигхэн морины туурайгаар
Жигдэлж индүүдэж байсан
Хатан Өэлүний үрс
Хан Чингисийн удам
Улсын зэрэгтэй түүхтэй
Хүний зэрэгтэй хүүтэй
Хуучин цагаар Хөх монгол
Хувьсгалаар сэрсэн Улаан монгол
Хөлөө майга болтол
Хүлгийн нуруун дээр явсан
Манан цэнхэр талын

Малчин жирийн ард
 Омогт Чингисийн сэлэм дээгүүр сэргэж
 Оюунт Хубилайн соёл дээгүүр мандаж
 Тогоонтөмөрийн улан дор гутаж
 Тоотой Богдын өвдөг дор сөхөрсөн
 Монгол минь ядуу орон
 Морин хуурын эгшгээр талыг уяраасан улс
 Дашдоржийн хүүгийн Миний нутаг
 Дамдинсүрэнгийн дуулсан Буурал ээжийн минь орон
 Алдарт Хүрэн морины минь хулжин явсан тал
 Ардын хүү Тооройн
 Амьдарч байсан нутаг”

гэсэн Ц.Гайтавтай хамтран бичсэн “Монголын тухай дуун” шүлэгтээ эх орныхоо туулж өнгөрүүлсэн үнэн түүхийг хүүрнэн өгүүлжээ. “Хүн чулуу” шүлэгтээ:

“... Энэ чулуун хүнд
 Эв дүй, ов мэх,
 Эрмэлзэл, туйлын зорилго
 Эрх ямба, хэргэм зэрэг,
 Эцэг эх, садан төрөл,
 Эхнэр хүүхэд нүгэл хилэнц
 Амьд хүний дотор юу багтдаг билээ
 Аанай л тэр бүхэн
 Энэ чулуун толгойд багтаж бий”

гэж дүрсэлжээ. Уран сайхны сэтгэлгээнд “энэ цэцэг яагаад энд хэвтэж байгаагаа яриад өгдөг болоосой”, “нутгийн минь уулс юу, юу үзсэнээ ярьдаг ч болоосой”, “уул ус маань гэрчилнэ” гэсэн өгүүлэмж хэвшсэн байдаг. “Хүн чулуу” шүлгийг ийм өгүүлэмж, ийм амьшуулал гэж үзвэл нээрээ л “өөрийнхөө тухай яриад өгөөсэй” гэсэн сюжет болно. Гэтэл төгсгөлдөө хүн чулууг, яагаад хүн гэж үзсэн учраа, амьдралын энгийн үнэнээр:

“... Хүнтэй адилхан чулууг бид
 Хүн чулуу гэж нэрлэдэг.
 Ерийн чулууг харин
 Ердөө л чулуу гэдэг”

гэж тайлжээ. Шүлгийн эхний хэсгээс мэдрэгдсэн хүн гэгч амьтны мөн чанар, амьдралын төлөөх зөрчил тэмцэл, шүүмжлэлт үзэл санаа агшин зуур тоглоом болон хувирав. Уг нь бид амьтай голтой хүн гэж бодож байтал, хэн нэгний, хэн нэгнийг дуурайж хийсэн хүн чулууны тухай болчихлоо. Шүлгийн уур амьсгал огцом зуур замхран, огт өөр ухаарал, бодомж болон хувирав. Бичгийн зохиолын гол шинж- таагдашгүй байх- гэдэг энэ нэг шалгуур Н.Нямдоржийн олон шүлэгт тусгалаа олсон байдаг. “Амарбаясгалант” шүлгийн:

“... Амарбаясгалант чамайг
Үүрд байна хэмээн
Үнэхээр хичээж босгосон нь гайхамшиг”

гэсэн дүрслэлээс “нээрээ л тийм дээ” гэмээр эерэг мэдрэмж төрж байтал,
гэнэт:

“Амарбаясгалант чамайг
Үзүүлэх ирээдүйгүй мэтээр
Үлдээхгүйг хичээсэн нь бас “гайхамшиг!”

шүүмжлэлт санаа буюу сөрөг мэдрэмж хослол нь болоод ороод ирж байна. Эерэг сөргийн энэ хослол нь бичгийн зохиолын үүднээс “сондгойруулахгүйн зарчим” болж байгаа бол, шүлэг зүйн талаасаа эн зэрэгцүүлэл юм. Харин уран дүрслэлийн ур маягийг ашигласан талаасаа эсрэгцүүлсэн дүрслэл болж байна. “Од” шүлэгтээ

“Тэртээ тэнгэрийн нэгэн чөлөөнд
Тэмдэгт нэгэн од миний од
Огт хөдөлшгүй бэх батаар
Одоо ч гэсэн тэндээ гялалзан байгаа
Өөрийнхөө тэр одыг
Өнөө ч би харнам”

гэж дүрсэлжээ. Ингэж найрагч өөрөө өөрийнхөө тухай “тэнгэрийн од -хүн юм” гэдэг хэвшилт зүйрлэл [formula] -ээр өгүүлэв. Ийн үзвэл тэнгэрт түгэх тэр олон од нь газарт амьдрах тэр олон хүн нь болж таарна. Утгын яг энэ өнцөг түүнд, шүлгийнхээ агуулга, уур амьсгалыг огт өөр шинж рүүгээ хувиргах боломжийг бий болгов. Туурвил зүйн энэ орчныг мэдэрсэн найрагч:

“Ямар хүний од хажууханд нь байгааг
Ялгаж үл танинам”

гэж бичжээ. Шүлгийн эхлэл -би- гийн тухай бахархалтай өгүүлэмж байсан бол, энэ мөрөөс эхлээд нийгмийн шүүмжлэлт сэтгэлгээ болчихлоо. Магадгүй энэ сөрөг дүрслэл, өөрийнх нь тухай үнэн өгүүлэмж байж болох ч, түүнээс илүүтэйгээр XX зууны монголчуудын туулж ирсэн хашигдмал, түгжигдмэл, мөрдлөг хавчлагатай хаалттай нийгмийг шүүмжилсэн сэтгэлгээ болсон байна. “Үүлэн бор” шүлэгтээ бичсэн:

“Үүлэн борд мордож
Элсэрхэг зөргийн
Хуурай тоос манаруулсаар
Элгэн нутгаараа
Салхи татуулан давхихад
Харсан ноход
Холоос угтаж ирснээ
Хавьтаж чадалгүй
Хөөж ядан хоцрохдоо

Нэрэлхсэн юм шиг
 Тарваганы нүх шиншилсээр
 Нэг хэсэг
 Гэртээ харилгүй тэнэнэ”

гэсэн хэсгээс далд утга, ухаарлын уур амьсгал мэдрэгдэнэ. Энэ бүхэн нь түүний уран бүтээл бичгийн зохиол болж чадсаныг нотолдог. Н.Нямдоржид “Зөгий” хэмээх нэгэн содон шүлэг бий. Шүлэгт:

“Хээр талаар
 Хэдэн арван бээрээр
 Хэрэн тэнэж

Аль л аглагхан, ариухан цэцгийн
 Амтат балыг
 Арвитгаж цуглуулна л

Ийм л сайхан ажлаар
 Ийм л сайхан амьдардаг
 Юутай сайхан чанартай
 Юутай сайхан амьтан бэ?”

гэж өгүүлжээ. Шүлэгт зөгийн талаар та бидний мэддэг тэр байдлын тухай зураглал дүрслэгджээ. Гэтэл Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургуулийн үндсэн ангийг төгссөн Утга зохиолын мэргэжилтний хувьд, өрнө дахины гүн ухаан, уран зохиолыг шимтэн хорхойсч уншиж судалдаг мэргэжлийн зохиолч хүний хувьд “Зөгий” шүлэг нь зөгийн амьдрал аж төрлийн тухай гэхээсээ, зөгийг бэлгэдэлт төлөөллөө болгож, түүгээр зохиолч хүний онгод авьяас, хөдөлмөр бүтээлийн мөн чанарын тухай өгүүлсэн гэвэл үнэнд илүү нийцнэ гэж үзэж байна. Ийн өгүүлэхийн учир нь, эртний Грекийн гүн ухаантан Сократ, Ионд хэлсэн нэгэн яриа болно. Энэхүү харилцаанд ийн өгүүлэв.

“For the poets tell us, I believe, that the songs they bring us are the sweets they cull from honey-dropping fountains [534b] in certain gardens and glades of the Muses—like the bees, and winging the air as these do.² And what they tell is true. For a poet is a light and winged and sacred thing, and is unable ever to indite until he has been inspired and put out of his senses, and his mind is no longer in him: every man, whilst he retains possession of that, is powerless to indite a verse or chant an oracle.²”

- “Учир нь яруу найрагчдын бидэнд авчирдаг дуунууд нь яг л зөгийн бал шиг юм. Яагаад гэвэл зөгий нь, амтат бал ундрэн дуслах ариухан 9 дагинын балын булгаас, амандаа дээжлэн, агаараар далавчлан дүүлдэг. Үүн шиг, яруу найрагч нь амтат шүлгийн бал зууж, онгодоор далавчлан бидэнд авчирдаг гэж би итгэдэг. Тэдний хэлэх нь үнэн юм. Яагаад гэвэл

² <https://www.perseus.tufts.edu/hopper/text?doc=Perseus>

яруу найрагч нь өд шиг хөнгөн далавчтай, ариун нандин бурханлаг сахиусны ертөнцийн хүн юм. Ийм бурханлаг сахиуслаг хүний оюун ухаан, энэ ертөнцийн эгэл хэмжээс, ерийн мэдлэгийн ухаанаас чадахын чинээ, хэмжээгээрээ мултран гарах тэрхэн агшинд, онгод нь орж ирж, шүлэг төрдөг. Үүнээс өөр үед шүлэг орж ирдэггүй. Аливаа хүнд онгод оршихгүй бол, тэр хүний хүч нь буурч, дуугаа дуулж, зөгнөж чадахгүй юм.” (534a-b)

Тэгэхээр Н.Нямдоржийн зөгий нь, онгодоор далавчлан амтат шүлгийн бал зууж, бидэнд авчирч өгч буй яруу найрагч ажээ. Яруу найрагч нь өд шиг хөнгөн далавчтай, ариун нандин бурханлаг сахиусны ертөнцийн хүн болж байна.

Энэ мэтээр шүлэг зохиолынх нь үнэт зүйл, уур амьсгал, орон зай нь тэр цагийн дийлэнх уран бүтээлчдийнхээс өөр, Монгол хүний амьдрал тэмцлийн утга учир, үүх түүх, Монголчуудын дундах эгэл жирийн явдлыг хэнд ч ойлгомжтой энгийн хэлээр өгүүлсэн байдал нь, аргагүй л тэр цагийн уншигчдын хүсэн хүлээж байсан сэтгэлгээ байжээ. Энэ хэрээр Н.Нямдоржийн яруу найргийн сэтгэлгээ, шүлэг зохиолынх нь уур амьсгал, орон зай Сэтгэлгээ - Үнэлэмж - Үнэлэлт - Туршлага - Асуудал бүхий БИЧГИЙН ЗОХИОЛ болж төлөвшиж, улам тэлэх байдалтай болж ирснийг хэдий хожим хойно ч гэлээ Ардын уран зохиолч С.Дашдооров, академич Х.Сампилдэндэв, шүүмжлэгч Б.Цэдэв нар өндрөөр үнэлсэн байдаг. Ялангуяа С.Дашдооров:

“... шүлэг болгон нь өвөрмөц ондоо, өөрөөр хэлбэл нэг хэсэг нь зурсан зураг шиг, нөгөө нь сэтгэн бодсон, зарим нь хэмнэл цохилтоороо хөтөлж яваа мэт буюу уншигчийг аяндаа хөтлөн танил боловч танихгүй ертөнц рүү шинэ санаа, шинэ өгүүлэмжээр хөтлөх мэт айзмаар бичигдсэн олон шүлэг найраглал туурвин “жирийн хүн өөрөө жинхэнэ цэвэр алт” болохыг магтан дуулсан”³

хэмээн бичсэн нь Нямдоржийн яруу найргийн мөн чанар буюу түүний шүлгүүд монгол бичгийн яруу найргийн туурвил зүйн сэтгэлгээнд арга барил, утга агуулгын талаар шинэчлэл хийснийг тодорхойлсон хэрэг байжээ. Академич Х.Сампилдэндэв Н.Нямдоржийг “Дорно”-ыг туурвисан дорнын их найрагч” гэж үнэлээд:

“Н.Нямдорж бол үзэл суртлын хийрхлээр бус сэтгэл зүрхний онгодоор шүлэг найраглалаа туурвидаг цөөхөн яруу найрагчийн нэгэн бөгөөд ийм учраас маркс Лениний сургаал, МАХН-ын яруу алдар, Октябрын хувьсгалын ач, орчин үеийн социалист бүтээн байгуулалтын тухай нялуун магтаалыг түүний уран бүтээлээс эрээд олохгүй. ... Чухам үнэнийг хэлэхэд Н.Нямдорж өрнийг үгүйсгэн, дорныг дөвийлгөн, хооронд сөргөлдүүлсэн шүлэг зохиол огтхон ч бичээгүй бөгөөд харин ч өрнө зүгийн боловсролтой дорно дахины яруу найрагчийн хувьд

³ Х.Сампилдэндэв “Дорно”-ыг туурвисан дорнын их найрагч” //Х.Сампилдэндэв “Монгол яруу найргийн товчоон” УБ., 1995, 82-р тал

оюун ухааныхаа шим тэжээлийг Оросын болон европын сонгодог уран зохиолоос авдаг нь түүний шүлэг найраглалаас илэрхий харагддаг билээ”⁴ хэмээн дүгнэсэн байлаа. Гэвч тухайн цаг үед энэ байдал нь, тэр цаг үе, нийгмийнхээ үнэт зүйл, улс төр, үзэл сурталд харш байсан учраас Н.Нямдоржийн уран бүтээл, шүлэг зохиолын тухай янз бүрийн шүүмж, өгүүлэл, яриа хөөрөө олонтоо гарч ирсэн байдаг. Энд зохиолч Ц.Цэдэнжав, шүүмжлэгч Г.Жамсранжав тэргүүт хүмүүсийн бичсэнийг “захиалга” гэж алгасаад, харин утга зохиолын онолын түвшний чадвартнуудын бичсэн зарим нэгэн жишээг дурдваас:

- “Орчин үеийн яруу найрагч хүн коммунист үзэл ялан мандаж, хүний суу билэг, ариун хөдөлмөр мянга мянган жилийн түүхэнд үзэгдээгүй бахархам их үйлсийг бүтээж байгаа түүхэн үеэ эс анзааран өнөөгийн сүр хүчит баатарлаг үйл явдлын дунд нүд балай, чих дүлий байж орчлонгийн жамыг бясалган сууж хэрхэвч таарахгүй. Түүхэн тодорхой цаг үеийн амьдрал тэмцэл бодол эрмэлзлийг тусгаснаараа уран бүтээл үнэ цэнтэй байдаг. Гэтэл тухайн цаг үеийн “тоос” ч халдаагүй орчлонгийн үзэгдлийг хийсвэрлэн бичсэн шүлэг зохиол тэр байтугай, түүвэр эмхэтгэл ч сүүлийн үед нэлээд гарах болжээ. Үүнд жишээ нь Н.Нямдоржийн “Монгол”, “Онон хатан эжий”, Д.Шагдарсүрэнгийн “Миний сайхан Монгол”, “Монгол хүний дуулал” зэрэг шүлэгт чухамдаа XX зууны 60-аад оны социалист шинэ монголын төрх байдал огтхон ч дүрслэлээ олсонгүй. Эдгээр шүлэгт байгалийн үзэсгэлэнг магтаж ерөнхийлөн шүлэглэсэн учраа чухам хэдий үеийн Монгол орон бэ гэдгийг олж танихын аргагүй байна. Түүхэн тодорхой эрин цаг, бодит байдлыг орчин үеийн хүний байр сууринаас урлан дүрслэхийн оронд ингэж амьдрал, байгаль, хувь заяа гэж юу болохыг хийсвэрлэн шүлэглэх нь социалист реализмын яруу найргийн зарчимд нийцэхгүй. Зарим залуу шүлэгч өнөөгийн оргилуун дэлгэр амьдрал дунд хүйтэн далайн давалгаанд “шидэгдсэн” завьхан адил дайвалзаж хоёр үзэл суртлын ширүүн тэмцлийн дундуур хөндлөнгийн хүн шиг алмайран гиюүрч, ерөнхий хийсвэр зүйл номнож суудаг нь тэвчишгүй үзэгдэл мөн. Манай залуу яруу найрагчдын бүтээлд хүн хүнээс гойд бичих гэж хэт мэрийх, эсвэл аль нэгэн нөлөөтэй зохиолчдын бичдэг ая хэлбэрийг давтан дуурайх гэм байна. Урлагийн тэнгэрийн эрдэнэсийн гэрэлд нүд нь гялбаж, сэтгэл нь хөөрсөн туршлагагүй залуу авьяастан “санаатай, санаагүй алин боловч” уншсан сонссон зохиолынхоо дагуу түүний амьсгалаар шүлэг найраг бичээд, түүнийгээ “уран сайхны шинэ нээлт” гэж гэнэн сэтгэлээсээ итгэдэг ч гэм бас байх шиг байна. Гүн итгэл бодол оюун сэтгэлийн “тамаас” ундрал гарсан уран үгс л хүн ардын зүрх сэтгэлд шингэж улирах цагийн тоосонд дарагдалгүй мөнхөрдөг жамтай.”
- “Өнгөрсөн онд хэвлэгдсэн Н.Нямдоржийн «Онон хатан эжий» гэдэг түүврийн талаар зөв зүйтэй шүүмжлэл манай сонин хэвлэлд нэгэнт

⁴ Х.Сампилдэндэв “Дорно”-ыг туурвисан дорнын их найрагч” //Х.Сампилдэндэв “Монгол яруу найргийн товчоон” Уб., 1995, 82-р тал

гарсан билээ. Утга зохиолын боловсролтой болсны хувьд ч гэсэн, үүний өмнө “Үүлэн бор” гэдэг нэлээд аятайхан түүвэр гаргасны хувьд ч гэсэн Нямдорж зэгсэн сайн бүтээл гаргах байх гэж бид бүхэн найдаж байлаа. Гэтэл энэ түүвэрт халуун зүрхнийх нь биш зээлдмэл этгээд харш үзэл санаа шургалсан учраас “Халуун зүрхний минь үзэл санаа «Хан Хэнтий шигээ өндөр болтугай” гэсэн зохиогчийн өөрийнх нь ерөөл бат оршиж чадахгүй болсон байна. “Аавынхаа хусан уургыг”, “Хаана ч юм нэгэн хотын хог дээр...”, “Цус”, “Дорно” зэрэг шүлгээс үзэхэд зохиогч чухам ямар үед амьдарч, хэний эрх ашгийг хамгаалж, ямар байр суурь баримталж, юуг эрмэлзэж байгаа нь ойлгогдохгүй байна. Н.Нямдорж “Этгээд сонин амьдралын олон өнгөт нугалаанд энгийн хүний үр эвдэрч муухай болдог юм” гэж зарлаад харийн зарим нэг шүлэгчийн харш үзэлтэй зохиолыг дуурайх гэж оролдсон нь социализмын үеийн яруу найргийн өнгө дэвсгэр дээр туйлын эв нийцгүй этгээд хачин харагдаж байна. Харш үзэл суртлын нян халдаж үтэл бэртэгчний хөгцөнд идэгдсэн “мөстсөн хөлдсөн хонгил...” шиг сэтгэл дотроо нээн илэрхийлж, зарчимгүй авирлах эрхийг бид хэнд ч олгохгүй. Ертөнцийг үзэх өөрийн хараагүй, бат зогссон байр суурьгүй, хэлбэрдэх чамирхахыг хэт хөөцөлдвөл, ард түмэндээ хэрэгтэй зохиол бүтээж чадахгүй, шүлэгчийн хувьд зэврэн мөхөхөд хүрдгийг залуу авьяастнууд анхаарах нь зүйтэй. Өнөө үеийн хүний нийгмийн хүсэл эрмэлзлийг илэрхийлэн гаргахаас зайлсхийж, хувийн бодолд явцуурвал үнэ цэнтэй бүтээл гаргаж чадахгүй.”

- “Манай авьяаслаг яруу найрагч Н.Нямдоржийн бүтээл олны анхаарлыг татдаг билээ. Энэ хүн нэг магтагдаж, нэг шүүмжлэгдэж явдаг яруу найрагч юм. Н.Нямдорж нэгэн үеэ бодвол сүүлийн үед нийгмийн том сэдэв рүү орж шүлэг зохиолынхоо сэдвийн хүрээг нэмж яваа хүн. Энэ нь сүүлийн үед бичсэн найраглалуудаас нь харагдаж байна. Гэвч шүлэг зохиолдоо хувийн “философио” шигтгэх, үзэгдэл юмст нийгмийн санааны үүднээс биш хувиасаа хэтэрхий хөнгөн ханддагаас болж зохиолынх нь үзэл суртал бүрхэгдэх явдал үзэгдсээр байна. Энэ нь Зохиолчдын хорооны яруу найргийн секцэд хэвлүүлэхээр ирүүлсэн “Буриад” гэдэг найраглал, зарим шүлэг зохиолоос нь харагдаж байна. Энд бас л зохиолчийн нийгэмд эзлэх байр сууриа хэрхэн ойлгож байгаа тухай сануулах хэрэгтэй болно. Нөгөө талаар сүүлийн үед бичсэн “Алт”, “Хөдөө”, “Газар”, “Ирээдүй” зэрэг найраглалууд нь бичлэгийн хэлбэр маягийн хувьд хоорондоо их ижил байгааг тэмдэглэх хэрэгтэй байна.”
- “Нямдорж ард түмэнд, уншигч олонд зориулж зохиол бичиж байгаа гэдгээ өндөр хариуцлагатай зүйл гэж ойлгоогүйгээс ном нь уншигчдад таалагдахгүй байна. ...Манай хүмүүсийн үзэл санаанд харш ийм зүйл бичсэн нь Нямдоржийн улс төр онолын мэдлэг нимгэнийг харуулаад зогсохгүй хэний төлөө зохиол бичиж байна вэ? гэдгээ ч төгс ухамсарлаагүй

байна гэхэд хилсдэхгүй биз ээ”

хэмээн үнэлж байсан нь өдгөө бараг л түүхэн баримт болох тийшээгээ хандчихжээ. 1963 оноос эхэлсэн энэ мэт үзэл суртлын хийсвэр үнэлэлтүүд “залуу авьяастнуудын сөрөг дуу хоолойг номхотгож ангич, намч байр сууринаас, социалист реализмын жаяг загварт багтсан зохиол бүтээл туурвиулах гэсэн зорилгодоо ямар нэгэн хэмжээгээр хүрсэн байх аа. Яагаад гэвэл тэр үеийнхэн дотроо толгой цохиж байсан Нямдоржийг намнасан нь түүнээс дутуу авьяас билигтнүүдийн зүрхэнд нь шар ус хурааж, мохоо дээрээс нь улам мохоо болгосон”⁵ ажээ.

Эдгээр шүүмжийг одоогийн өндөрлөгөөс дахин нэг сөхөхөд, социалист нийгмийн гишүүн, иргэн Н.Нямдоржийг хувь хүний талаас нь хохироож чадсан ч, уран бүтээлийнх нь үүднээс харвал Н.Нямдоржийг уншигчдаас нь холдуулах биш, харин ч “Онон хатан ээжий”-г, “Дорно”-г, “Цус”-г, “Үүлэн бор”-ыг уншихаар, цээжлэхээр, тэмдэглэлийн дэвтэртээ бичиж хадгалахаар, дурсгалын дэвтэр зэрэгт гар бичмэлээр түгэн дэлгэрч, хошууран дайрахад хүргэсэн реклам болсон юм билээ.

Эцэст нь тэмдэглэхэд Н.Нямдоржийн шүлгүүд бол уран бүтээлчийн чадал зааж, чансаа сорьсон бичгийн зохиол болч чадсан гэдгийг дахин тэмдэглэхийг хүсч байна. Тиймээс тэрээр өөрийн уран бүтээлээрээ:

1. Цаг үеийн нийгэм, улс төрийн ерөнхий чиг шугам, бодлогод захирагдалгүй ямар нэгэн хэмжээгээр жинхэнэ бичгийн зохиол туурвихын үлгэр үзүүлсэн
2. Гоо зүй, уран сайхны үнэ цэн, үнэлэмж бүхий бичгийн зохиол туурвихын жишээ болсон
3. Амьдралын үнэнийг илэрхийлэхдээ дорнын гүн сэтгэлгээнд суурилсан мөн чанарын шүтэлцээ холбоог хэрхэн дүрсэлдгийг харуулсан бодит баримт болсон байна.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.

⁵ С.Лочин “XX зууны монголын журамлагдсан уран зохиол” Уб., 2003, 203-р тал